



# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1. Авто замын засвар, нөхөөсний ажлыг эрчимжүүлэх.  
(Улсын байцаагч нарыг газар дээр нь ажиллуулах)

*Хугацаа: 06 дугаар сарын 30-ны дотор*





## Биелэлт: Орхон АЗЗА ТӨХК

2024 оны 06 дугаар сарын 22-27-ны өдрүүдэд А1001 дугаартай авто замын 135 км-138км-ын хооронд 480м<sup>2</sup> талбайн суурь ухаж, асфальтбетон хольц авч хучихад бэлтгэсэн. Хотын доторх хатуу хучилттай авто замд 830м<sup>2</sup> талбайн нүхэн эвдрэлийг засварлаад байна. Дэнж багийн 200м<sup>2</sup> талбайн нүхэн эвдрэлийг хайрган материалаар дүүргэлт хийсэн.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*



2. Үерийн далан сувагт үзлэг шалгалт хийж, цэвэрлэх ажлыг эрчимжүүлэх. Үер усны үед ажиллах ажлын төлөвлөгөө гаргаж танилцуулах.

*Хугацаа: Тухай бүрд*





## Биелэлт: ХЗА

Гэр хорооллын үерийн сувгийг хааж шороо асгасан байршилд ОБГ, ГХБХБГ, Баян-Өндөр сумтай хамтарч үзлэг хийж Эрдэнэ багт үерийн сувгийг бөглөж барилга барих гэж байсан иргэнд холбогдох бичгийг хүргүүлж зөрчлийг арилгуулахаар ажиллаж байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*





3. Хүүхдийн тоглоомын талбайд үзлэг хийж сэргээн завсарлах ажилд онцгой анхаарах.

*Хугацаа: Ойрын хугацаанд*





## Биелэлт: ХТГ

Хүүхдийн тоглоомын талбайд үзлэг шалгалт хийж Зэст, Оюут, Уурхайчин, Хүрэнбулаг, Яргуйт багуудын 7 хүүхдийн тоглоомын талбайд засвар хийж аюулгүй байдлыг хангасан. Мөн Зэст багийн 3, Оюут багийн 4 хүүхдийн тоглоомын талбайд элс буулгасан.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*

НАЙРАМДАА - ДУУЖДА



4. Хот дотор мал орж ирж байгаа асуудалд онцгой анхаарах, камерын хяналтыг ашиглах. Хотын ойр буусан айлуудад мэдэгдэл хүргүүлж ажиллах.

*Хугацаа: Тухай бүрд*







## Биелэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ

Хотын ногоон бүсэд буусан 17 малчин өрхөд хотын төвд мал оруулсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авахыг сануулж, 3 хоногийн дотор нүүх мэдэгдлийг хүргүүлсэн.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*





Биелэлт: МШУТ

Биелэлт ирүүлээгүй





5. Үерийн суваг, шуудуу хааж шороо овоолсон газруудад яаралтай арга хэмжээ авч зөрчлийг арилгах.

*Хугацаа: Тухай бүрд*





## Биелэлт: Баян-Өндөр сумын ЗДТГ

Эрдэнэ багийн Жаргалантын хэсэгт үерийн суваг, шуудуу хааж шороо асгасан 12 иргэний судалгааг гаргаж, зөвлөмж хүргэн зөрчлийг арилгуулахаар ажиллаж байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*





## Биелэлт: Жаргалант сумын ЗДТГ

Үерийн суваг шуудуунд үзлэг шалгалт хийж Улаантолгой багийн зүүн талын үерийн далангийн зориулалтыг өөрчилж борооны усыг мод үржүүлгийн талбай руу оруулсан зөрчлийг илрүүлж, даланг ковшоор сэргээн засварласан. Мөн иргэдэд дахин даланг өөрчлөхгүй байх албан мэдэгдлийг байгаль орчны хэсгээс хүргүүлсэн.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*





6. Хотын мод бут сөөгийг хэлбэржүүлэх, хотын хэмжээнд зэрлэг ургамал устгалын ажлыг зохион байгуулах. Усалгааг тогтмол хийх.

*Хугацаа: 07 дугаар сарын 12-ны дотор*





## Биелэлт: ХЗА

**ЦНБГ** нь нийтийн эзэмшлийн гудамж талбайн 390м ургамалан хашлага, шар хуайсыг тайрч тэгшлээд байна. Нийт 10800м<sup>2</sup> талбайн зэрлэг ургамал, шарилжийг хадаж цэвэрлэн гарсан хог хаягдалыг хогийн цэгт буулгалаа.

**ХТГ** нь орон сууцны хороолол дундах шарилж болон зэрлэг хог ургамалын цэвэрлэгээ Хүрэнбулаг, Согоот, Уурхайчин багуудад хийгдэж эхэллээ.

Нийт 26 СӨХ 6843.3м<sup>2</sup> талбайн шарилж устгалын ажил хийгээд байна.

*Хэрэгжилт: Хэрэгжиж байна.*



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2024 он

НАЙРАМДАЛ - ДРЧУЖДА

